



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2011 оны 05 сарын 01-ны
өдрийн 3719 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДИН ТУШААЛ

2011 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А
143

Улаанбаатар хот

Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах,
халдвартгүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд
бүртгэх журмыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам"-ыг нэгдүгээр, "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисын улсын бүртгэлийн гэрчилгээний загвар"-ыг хоёрдугаар, "Бүртгэлийн өргөдлийн маяг"-ыг гуравдугаар, "Бодисын хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны зааврын маяг"-ыг дөрөвдүгээр, "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх ажил үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын тайлан мэдээний маяг"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх үйл ажиллагааны тайлан мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, ирүүлсэн мэдээг нэгтгэж жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт хүргүүлж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.
3. Тухайн жилд Монгол Улсад ашиглаж болох ахуйн хортон, шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдвартгүйжүүлэлтийн бүртгэгдсэн бодисын жагсаалтыг хамтарсан тушаалд тусгаж байхыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.
4. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



080509

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 22-ны өдрийн
А/1 дугаар тушаалын 1 дүгээр
143 хавсралт

АХҮЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Эрүүл мэндийн байгууллага, нийтийн үйлчилгээний газар, хоол, хүнс, цэцэрлэг, сургууль болон ахуйн зориулалтаар хэрэглэх дотоодын болон импортын ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисыг Монгол Улсад бүртгэх, бүртгэлийн хугацааг сунгах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах асуудлыг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. ЭМЯ-ны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) нь эдгээр бодисыг улсын бүртгэлд бүртгэх, сунгах, хүчингүй болгох асуудлаар шийдвэр гаргана.
- 1.3. ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газар нь (цаашид “ажлын алба” гэх) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисын бүртгэлтэй холбоотой зөвлөлийг хуралдуулж аж, ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг хэлэлцүүлэн, хурлын шийдвэрийг үндэслэн гэрчилгээ олгох, мэдээний санд оруулах, холбогдох байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг хариуцна.
- 1.4. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодис бүртгүүлэх хүсэлт гаргагч (цаашид “бүртгүүлэгч” гэх) нь Эрүүл мэндийн тухай хуулийн 41.1-д заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна.
- 1.5. Халдварт өвчин судлалын үндэсний төв (цаашид ХӨСҮТ гэх) нь улсын бүртгэлд бүртгүүлэх бодисын материалыг хүлээн авах, шинжээчийн дүгнэлт гаргуулах үйл ажиллагааг хариуцна.
- 1.6. ЭМЯ-ны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөл ахуйн шавж мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисын бүртгэлийн материалд дүгнэлт гаргах шинжээчийн ажиллах журам, бодисын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааны зардлыг батална.
- 1.7. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааны зардлыг бүртгүүлэгч тал хариуцна.

Хоёр. Бүртгэх үйл ажиллагаа

- 2.1. Бүртгүүлэгч байгууллага нь бодисыг бүртгүүлэх тухай хүсэлт, бодистой холбоотой шаардлагатай баримт бичгийн электрон болон цаасан хувийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлнэ.

- 2.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь бүртгүүлэгчээс ирүүлсэн материалыг бүртгэлд тавигдах шаардлагын дагуу бичиг баримтыг бүрэн бүрдүүлсэн эсэхийг ажлын 20 хоногт нягтлан, шалгана.
- 2.3. Бүртгүүлэгчээс ирүүлсэн материал бүртгэлд тавигдах шаардлагыг хангасан тохиолдолд материалыг хүлээн авсанд тооцож томилогдсон шинжээчид материалыг хүлээлгэн өгнө.
- 2.4. Тамга тэмдэггүй, бүрдүүлэх материалыг дутуу ирүүлсэн, хуурамч бичиг баримт ирүүлсэн бол шаардлага хангаагүйд тооцож материалыг бүртгүүлэгчид буцаана.
- 2.5. Томилогдсон шинжээч тухайн бодист гаргасан дүгнэлтээ ХӨСҮТ-д ирүүлнэ. ХӨСҮТ нь ХАБХМ33-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх бодисын материалыг бэлтгэж ажлын албан албан бичгээр хүргүүлнэ.
- 2.6. Ажлын алба нь шаардлагаатай тохиолдолд тухайн бодисын бүртгэлийн асуудлаар үйлдвэрлэгч болон эрх бүхий байгууллагаас холбогдох тодруулга авна.
- 2.7. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгч, улс, бодисын хэлбэр, концентраци тус бүрээр нь улсын бүртгэлд бүртгэнэ.
- 2.8. Ажлын алба нь ХАБХМ33-ийн хурлаар бодис бүртгэх асуудлыг хэлэлцүүлж, хурлын шийдвэрээр бодисыг 3 жилийн хугацаагаар бүртгэж гэрчилгээ олгох ба 3 жилийн хугацаагаар сунгана. Энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу гэрчилгээний загварыг хэрэглэнэ.
- 2.9. Ажлын алба ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисыг бүртгэхгүй, буцаасан хурлын шийдвэр гарсан тохиолдолд тухайн байгууллагад албан бичгээр ажлын 5 хоногийн дотор шийдвэрийг хүргүүлнэ.
- 2.10. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдвартгүйжүүлэх бодисын бүртгэлд дараахь бодисыг бүртгэнэ. Үүнд:
- 2.10.1. Шинээр хэрэглэх ахуйн шавж, мэрэгч устгах бодис;
 - 2.10.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинээр хэрэглэх ариутгах, халдвартгүйжүүлэх бодис (гадаргуу, багаж, тоног төхөөрөмж, гар, арьс, салст халдвартгүйжүүлэх);
 - 2.10.3. Ахуйн нөхцөлд шинээр хэрэглэх ахуйн шавж, мэрэгчээс хамгаалах бодис (шавжаас сэргийлэх арьсны түрхлэг, цацлага, ялтас, тор, үргээгч, мэрэгчийн өгөөш г.м.);
 - 2.10.4. Нийтийн үйлчилгээний газруудад хэрэглэх халдвартгүйжүүлэх бодис;
 - 2.10.5. Хүнсний үйлдвэрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, гадаргууд хэрэглэх халдвартгүйжүүлэх бодис.

Гурав. Бүртгэлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

- 3.1. Улсын бүртгэлд бүртгүүлэх бодис нь дараахь шаардлага хангасан байна. Үүнд:
- 3.1.1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ), Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO), Америкийн хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг (EPA), Америкийн шавж, мэрэгч

устгал, мөөгөнцрийн эсрэг бодисын тухай хууль (FIFRA) зэргийн зөвлөмж болгосон ISO:9001, ISO 14001 стандартын шаардлагыг хангасан байх;

3.1.2. Экспортлогч улсын үйлдвэрлэгч байгууллагаар баталгаажуулсан тухайн бодисын сертификат, гарал үүслийн гэрчилгээ, чанарын гэрчилгээтэй байх;

3.1.3. Экспортлогч улсын үйлдвэрлэгч байгууллагаар баталгаажуулсан лабораторийн шинжилгээний бичигтэй байх;

3.1.4. Экспортлогч улсын үйлдвэрлэгч байгууллагаас тухайн улсдаа 3-аас доошгүй жил хэрэглэгдэж сөрөг нөлөөгүй болохыг баталгаажуулсан албан ёсны бичигтэй байх;

3.1.5. Бүртгүүлэх бодисын үйлчлэл, чанар, аюулгүй байдал нь улсын бүртгэлтэй ижил төстэй бодисынхос давуу болох нь шинжээчийн дүгнэлт, судалгааны дүнгээр баталгаажсан;

3.1.6. Үйлдвэрлэгч болон эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан баримт бичгийн үнэн зөвийг (орчуулга, гэрчилгээний хуулбар, хэрэглэх, найруулах заавар, аюулгүй ажиллагаа гэх мэт) бүртгүүлэгч болон үйлдвэрлэгч тал хариуцана;

3.2. Импортын бодис бүртгүүлэхдээ дараахь бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд:

3.2.1. Бодис бүртгүүлэх байгууллагын албан хүсэлт;

3.2.2. Бодис бүртгүүлэх өргөдөл /3 дугаар хавсралтын дагуу/;

3.2.3. Ахуйн шавж мэрэгч устгах, ариутгах, халдвартгуйжүүлэх бодис импортлох, худалдах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар батлагдсан хуулбар;

3.2.4. Тухайн бодисын дагалдах сертификат;

3.2.5. Тухайн бодисын нэршил олон улсын бүртгэлийн дугаар (CAS), найрлага шинж чанар, болзошгүй эрсдэл, ашиглах тун хэмжээ, тээвэрлэх, хадгалах, устгах заавар, аргачлал зэрэг мэдээллийг агуулсан хор аюулын лавлах мэдээллийн монгол хэл дээрх баталгаат орчуулга;

3.2.6. Тухайн бодисын үйлдвэрлэгчээс гаргасан хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны заавар /4 дүгээр хавсралтын дагуу/;

3.2.7. Эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдэд зориулсан бодисын ашиглах зааврын монгол хэл дээрх баталгаат орчуулга;

3.2.8. Үйлдвэрлэгч болон борлуулагч байгууллагын монгол хэл дээрх танилцуулга, баталгаат орчуулга;

3.2.9. Бүртгүүлэгчийн үйлдвэрлэгч байгууллагатай хийсэн албан ёсны гэрээний нотариатын хуулбар, монгол хэл дээрх баталгаат орчуулга;

3.2.10. Үйлдвэрлэгч байгууллагаас бусад гуравдагч хуулийн этгээд, аж ахуйн нэгжээс худалдан авах тохиолдолд үйлдвэрлэгч байгууллагын зөвшөөрлийг хавсаргана;

3.2.11. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дунд үндэслэн гаргасан улсын байцаагчийн дүгнэлт;

3.2.12. Тухайн бодисын үйлчилгээ үр дүнг баталсан мэргэжлийн байгууллагын хийсэн сорилт туршилт судалгааны дүн;

3.2.13. Анхдагч болон хоёрдогч савалгааны зураг, загвар дээж;

3.3. Үндэсний үйлдвэрийн бодис бүртгүүлэхэд дараахь бичиг баримтыг ирүүлнэ.
Үүнд:

- 3.3.1. Бодис бүртгүүлэх байгууллагын албан хүсэлт;
- 3.3.2. Бодис бүртгүүлэх өргөдөл /3 дугаар хавсралтын дагуу/;
- 3.3.3. Ахуйн шавж мэрэгч устгах, ариутгах, халдвартгүүлэх бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар батлагдсан хуулбар;
- 3.3.4. Эрх бүхий байгууллагын олгосон оюуны өмчийн гэрчилгээний хуулбар;
- 3.3.5. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд /шинээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 2 цувралд/ хийсэн шинжилгээний дүн;
- 3.3.6. Бодист тавигдах ерөнхий шаардлагын үндэсний стандарт буюу техникийн нөхцлийг тодорхойлон баталсан стандарт;
- 3.3.7. Тухайн бодисын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн гаргасан улсын байцаагчийн дүгнэлт;
- 3.3.8. Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үүсгэх нөлөөний тухай судалгааны үр дүн ба илэрсэн гаж нөлөөний судалгааны дүн;
- 3.3.9. Эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдэд зориулсан ашиглах заавар /монгол хэл дээр/;
- 3.3.10. Тухайн бодисын нэршил олон улсын бүртгэлийн дугаар(CAS), найрлага шинж чанар, болзошгүй эрсдэл, ашиглах тун хэмжээ, тээвэрлэх, хадгалах, устгах заавар, аргачлал;
- 3.3.11. Тухайн бодисын үйлдвэрлэгчийн гаргасан хэрэглэх арга аюулгүй ажиллагааны заавар /4 дүгээр хавсралтын дагуу/;
- 3.3.12. Анхдагч болон хоёрдогч савалгааны зураг, загвар дээж.

Дөрөв. Бүртгэлийг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох


4.1. Тухайн бодисыг бүртгүүлсэн байгууллага нь бүртгэлийг өөрчлөх, хугацааг сунгахтай холбоотой хүсэлтийг ирүүлнэ;

4.2. Бүртгүүлэгч бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө хугацааг сунгуулах хүсэлтээ гаргана;

4.3. Бодисын бүртгэлийн хугацааг сунгуулахад дараахь баримт бичгийг ирүүлнэ.
Үүнд:

- 4.3.1. Бүртгэлийн хугацааг сунгуулах хүсэлт;
- 4.3.2. Бодис бүртгүүлэх өргөдөл /3 дугаар хавсралтын дагуу/;
- 4.3.3. Хугацаа дууссан бодисын бүртгэлийн гэрчилгээний хуулбар хувь;
- 4.3.4: Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн гаргасан улсын байцаагчийн дүгнэлт;
- 4.3.5. Хэрэглэх хугацаанд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хортой үйлчлэл илэрсэн талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан эсэх;

- 4.3.6. Экспортлогч улсын үйлдвэрлэгч байгууллагаас тухайн улсад сүүлийн 2 жил хэрэглэгдэж байгаа сөрөг нөлөөгүй болохыг баталгаажуулсан албан ёсны бичиг;
- 4.4. Дараахь тохиолдолд бүртгэлийг өөрчлөх шаардлагатай гэж үзэх бөгөөд өөрчлөлтийг бодисын бүртгэлд бүртгэнэ. Үүнд:
- 4.4.1. Хэрэглэх зааврын өөрчлөлт;
 - 4.4.2. Үйлдвэрлэгчийн нэр, хаягийн өөрчлөлт (гарал үүслийн улс өөрчлөгдөөгүй тохиолдолд);
 - 4.4.3. Туслах болон будагч бодисын найрлага, концентрацийн өөрчлөлт (олон улсад зөвшөөрөгдсөн бодисоор солих гм);
- 4.5. Бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 4.5.1. Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай байгууллага эсвэл үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
 - 4.5.2. Бодис бүртгүүлэх өргөдөл /3 дугаар хавсралтын дагуу/;
 - 4.5.3. Өөрчлөлтийн дэлгэрэнгүй тайлбар, холбогдох баримт бичиг;
 - 4.5.4. Анхдагч болон хоёрдогч савлалт хаяглалт, шошгын өнгөт зураг;
- 4.6. ХАБХМЗ зөвлөлөөс дараахь тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгоно. Үүнд:
- 4.6.1. Олон улсын хэмжээнд хэрэглэхийг хориглосон;
 - 4.6.2. Монгол Улсын хориглосон болон хязгаарласан химийн бодисын жагсаалтанд орсон;
 - 4.6.3. Бүртгүүлэгч болон үйлдвэрлэгчээс бүртгэлийг хүчингүй болгох албан хүсэлт ирүүлсэн;
 - 4.6.4. Бодисын чанар аюулгүй байдлын талаар эрүүл мэндийн байгууллага, иргэдээс ирсэн гомдлын дагуу хууль, мэргэжлийн хяналтын байгууллага шалган шийдвэрлэсний дагуу бүртгэлээс хасах санал ирүүлсэн;
 - 4.6.5. Бодисын хэрэглэх явцад ноцтой хор нөлөө илэрсэн;
 - 4.6.6. Бодис нь чанарын шаардлага хангахгүй болохыг итгэмжлэгдсэн болон лавлагaa лабораторийн шинжилгээгээр нотолсон;
 - 4.6.7. Үйлдвэрлэлийн технологи хоцрогдсоноос чанарын шаардлага хангахгүй болсон;
 - 4.6.8. Зах зээлд хуурамчаар их хэмжээгээр түгээгдсэн талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан;
 - 4.6.9. Үйлдвэрлэгч нь үйлдвэрлэхээ больсон;
 - 4.6.10. Бүртгэлийн хугацаа дууссанаас хойш 1 жилийн дотор дахин сунгалт хийгдээгүй тохиолдолд;
 - 4.6.11. Хуурамч бичиг баримт бүрдүүлэн бүртгүүлэх, бүртгэлийг өөрчлөх, хугацаа сунгуулахтай холбоотой шийдвэр гаргуулсан болохыг хууль хяналтын байгууллага тогтоосон



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04. сарын 13.-ны өдрийн
143 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Соёмбо
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
MINISTRY OF HEALTH OF MONGOLIA
АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
БОДИСЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
INSECTICIDE, RODENTICIDE, ANTICEPTIC, DISINFECTANT
REGISTRATIONCERTIFICATE

Бүртгэлийн дугаар -----

Registration number

Бодисын олон улсын нэршил -----

International name of the chemical

Бодисын худалдааны нэршил -----

Trade name of the chemical

Үйлчлэгч бодисын нэр, агууламж -----

Active ingredient and concentration of chemical

CAS-ын дугаар -----

CASnumber

Бодисын хэлбэр,савлалтын хэмжээ -----

Chemicals form, package dosage

Хэрэглэх зориулалт -----

Intended use

Үйлдвэрлэгчийн нэр -----

Manufacturer name

Гарал үүслийн улс -----

Country of origin

Бүртгэл ньонысарынөдөр хүртэл хүчинтэй.

Registration valid until _____(day) _____(month) _____(year)

Эрүүл Мэндийн Дэд сайд-----

Vice Minister for Health-----

(Гарын үсэг)

(Тамга)

(Нэр)

(Signature)

(Stamp)

(Name)

906744355AA0576 1111126516

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04. сарын 23.-ны өдрийн
143 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)

- Шинээр бүртгүүлэх
- Бүртгэлд өөрчлөлт оруулах
- Хугацаа сунгуулах


I ХЭСЭГ	ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ Өртөдөл гаргагч нь Монгол Улсад ахуйн шавж мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодис импортлох, худалдах байгууллага байна.
Байгууллагын нэр	
Байгууллагын хаяг	
Шуудангийн хаяг	
Утасны дугаар	
Факсын дугаар	
Е майл хаяг	
Харилцах хүн, утасны дугаар	
II ХЭСЭГ	Бүтээгдэхүүний талаарх мэдээлэл
Үйлдвэрлэсэн улсын нэр	
Үйлдвэрлэсэн компанийн нэр	
Бодисын худалдааны нэршил	
Үйлчлэгч бодисын нэр, хувь хэмжээ	
Нэр	Хувь
1	1
2	2
3	3
Туслах бодисын нэр, хувь хэмжээ	
Нэр	Хувь
1	1
2	2
3	3
Бодисын хэлбэр	
Хадгалах нөхцөл	
Хүчинтэй хугацаа	
Савалттын хэлбэр	
Савалттын хэмжээ	

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 07 сарын 13.-ны өдрийн
4 дугаар тушаалын 4 дүгээр
143 хавсралт

БОДИСЫН ХЭРЭГЛЭХ АРГА, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

1	Бодисын худалдааны нэр
2	Олон улсын ангилал, CAS
3	Химийн найрлага, гарал ангилал
4	Үйлчлэгч бодисын нэр, хувь концентраци
5	Химийн томьёо
6	Савлалт, жин
7	Хорын зэрэг
8	Үйлдвэрлэгч улс
9	Үйлдвэрлэгч байгууллага
10	Хадгалах нөхцөл
11	Хэрэглэх заалт
12	Хэрэглэх найруулах заавар
13	Ашиглах багаж
14	Хориглох заалт
15	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, авах арга хэмжээ
16	Найруулсан ажлын уусмыг хадгалах хугацаа, нөхцөл
17	Тээвэрлэх үеийн шаардлага
18	Устгал

Жижиглэнгээр худалдах бол иргэдэд зориулсан санамжийг хавсаргана.





Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 13-ны өдрийн
Дугаар тушаалтын 5 дугаар
хавсралт

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖУУЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН МЭДЭЭНИЙ МАЯГТ

Maytag A

Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдвартай жүүлэх ажил үйлчилгээнд нэгдсэн бүртгэл

Тайлбар: Тухайн байгууллагад хөтлөгднө.

Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүүлэх бодисын нэгдсэн бүртгэл




.....(аймаг, дүүрэг) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх
үйлчилгээ эрхэлж буй (нэгж)-ийноны үйл ажиллагааны жилийн
эцсийн тайлан

Д/д	Объект	Үйлчилгээ		Үйлчилгээ хийсэн нийт талбай	Тайлбар
		Нэр	Тоо		
1.	Үйлдвэр		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
2.	Эмнэлэг		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
3.	Хүнс, худалдаа		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
4.	Соёл		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
5.	Хүүхдийн байгууллага		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
6.	Орон сууц /байр/		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
7.	Гэрийн хороо /хашаа/		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
8.	Ил задгай талбай		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
9.	Төвлөрсөн хогийн цэг		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
10.	Дулааны шугам		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
11.	Бусад		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		
12.	Дүн		Халдваргүйжүүлэлт		
			Шавжгүйтгэл		
			Мэрэгчгүйтгэл		

9087443 УХА0578 1116126516

.....(аймаг, дүүрэг) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартайжүүлэх үйлчилгээ эрхэлж буй.....(нэгж)-ийн...оны хүний нөөцийн жилийн эцсийн тайлан

№	Үндсэн мэргэжил	Эрхэлж буй албан тушаал		Сургууль төгссөн он	Халдвар судлалын чиглэлээр мэргэжил эзэмшсэн он	Тухайн онд шинээр ажилд орсон хүн
		Үндсэн орон тоогоор	Гэрээгээр			
1.	Тархвар судлаач эмч					
2.	Хүний их эмч					
3.	Химич					
4.	Биологч					
5.	Сувилагч					
6.	Ариутгагч					
7.	Бусад дээд мэргэжилтэн					
8.	Бусад дунд мэргэжилтэн					
9.	Мэргэжилгүй					
	Дүн					



Маягт д.

.....ОНД импортлох, худалдах ахуйн шавж, мэрэгч устах, ариутгах халдвартгийгүйлэх бодисын жагсаалт

Тайлбар: Импортлох зөвшөөрөлтэй аж ахуйн Нэгж хөтөлнө.

Тайлан гаргасан: _____ /
Хянасан: _____ /